

## СОНГОХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН МОНИТОРИНГИЙН ИЛТГЭХ ХУУДАС

Улаанбаатар хот

2012.07.02.

Хүний эрхийн Үндэсний Комисс нь 2012 оны Улсын Их Хурлын болон Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд эрх чөлөө нь хуулийн дагуу хязгаарлагдсан буюу цагдан хоригдсон, захиргааны журмаар албадан саатуулагдсан, баривчлагдсан хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хугацаат болон гэрээт цэргийн алба хаагчдын сонгох эрхээ эдлэх, сонгуульд оролцох боломжийг бүрдүүлэх талаар холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллалаа.

Комиссын даргын баталсан удирдамжийн дагуу сонгуулийн бэлтгэл ажил, зохион байгуулалттай холбоотойгоор цагдан хоригдсон, захиргааны журмаар албадан саатуулагдсан, баривчлагдсан хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хугацаат болон гэрээт цэргийн алба хаагчдын сонгох эрхийг хэрэгжүүлэх чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэв.

### **Сонгуулийн өмнөх бэлтгэл ажил, зохион байгуулалтын чиглэлээр:**

Сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулахад оролцох төрийн чиг үүрэг бүхий байгууллагуудтай үе шаттай уулзалтуудыг зохион байгуулав. Үүнд:

- 2012 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр Хүний эрхийн Үндэсний Комисс, Сонгуулийн ерөнхий хороо, Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газар, Цагдаагийн Ерөнхий Газрын удирдлагуудтай тухайн асуудлаар санал солилцох уулзалт;
- 2012 оны 5 дугаар сарын 04-ны өдөр Хүний эрхийн Үндэсний Комисс, Сонгуулийн Ерөнхий Хороо, Зэвсэгт хүчний Жанжин Штаб, Хил хамгаалах Ерөнхий Газар, Дотоодын цэргийн штабын удирдлагуудтай санал солилцох уулзалт;

Түүнчлэн, 2012 оны 4 дүгээр сарын 18, 2012 оны 5 дугаар сарын 24-ний өдрүүдэд Хүний эрхийн Үндэсний Комисс, Сонгуулийн ерөнхий хороо, Сонгогчдын боловсрол төв, Мерси-Кор Монгол олон улсын байгууллага, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллагын төлөөлөлтэй санал солилцох уулзалтуудыг тус тус хийв.

Эдгээр уулзалтуудын үр дүнд талууд зөвшилцөн, дараах арга хэмжээг хамтран хэрэгжүүлэхээр боллоо.

- Уулзалтын үеэр УБЕГ-аас өгсөн мэдээллээр шинээр иргэний бичиг баримт авах 14000 гаруй иргэд байгаа бөгөөд энэ тоо цаашид өсөх хандлагатай байгаа тул иргэдийг цахим үнэмлэхжүүлэх асуудлыг Улсын Их Хуралд танилцуулж, холбогдох шийдвэрийг яаралтай гаргуулах;
- Захиргааны журмаар баривчлагдсан, албадан саатуулагдсан, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу баривчлагдсан, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан сонгогчдын нэрийн жагсаалтыг Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газар, Цагдаагийн Ерөнхий Газар хуульд заасан хугацаанд цаг тухай бүр гаргаж, иргэний бичиг баримтгүй хүмүүсийн мэдээллийг Улсын Бүртгэлийн Ерөнхий Газарт хүргүүлж, шинэчилсэн бүртгэл хамруулах, цахим үнэмлэхжүүлэх;

- Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд сонгогчид саналаа иргэний үнэмлэхтэй өгөхөөр хуульчилсан тул 2012 оны 2 дугаар ээлжийн цэрэг татлага болж байгаатай холбогдуулан шинээр цахим үнэмлэх авахаар хүлээгдэж байгаа 18 насанд хүрсэн залуусыг лавлагааны хуудсаар цэрэгт татаж, Зэвсэгт хүчний Жанжин Штаб, Хил хамгаалах Ерөнхий Газар, Дотоодын цэргийн штабаас лавлагааны хуудастай цэргүүдийн нэгдсэн бүртгэлийг гарган, Улсын Бүртгэлийн Ерөнхий Газарт хүргүүлж, цахим үнэмлэхжүүлэх ажлыг хамтран зохион байгуулах;
- Хил Хамгаалах Ерөнхий Газрын хилийн ангиудын застав, харуулд байгаа цэргийн алба хаагчдын сонгууль өгөхөд застав, харуулаас цэргийн алба хаагчдыг ангийн төвд хүргэх бензин шатахууны асуудал Хил Хамгаалах Ерөнхий Газрын төсөвт суудаггүйгээс хүндрэл үүсгэдэг байна. Иймд хилийн застав, харуулд байгаа цэргийн алба хаагчдын сонгуулийн санал өгөхтэй холбоотой гарах бензин шатахууны төсвийн тооцооллыг Хил Хамгаалах Ерөнхий Газраас гаргаж, Сонгуулийн Ерөнхий Хороотой хамтран Засгийн газарт тавьж шийдвэрлүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгууль өгөх боломжийг бүрдүүлэх талаар Сонгуулийн Ерөнхий Хорооноос сонгуулийн тойргийн хороодод ажлын чиглэл өгүүлэх;

### **Сонгогчдын боловсролыг дээшлүүлэх талаарх сурталчилгааны ажил:**

Комисс нь Сонгуулийн ерөнхий хороотой хамтран захиргааны журмаар баривчлагдсан, албадан саатуулагдсан, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу баривчлагдсан, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан сонгогчдод зориулан зөөврийн битүүмжилсэн хайрцагар санал өгөхтэй холбоотой асуудлаар эвхмэл хуудсыг боловсруулан 1200 ширхэг хэвлүүлж, ШШГЕГ-500, ЦЕГ-500, НЦГ-ын Албадан саатуулах төвд-200 ширхэгийг; Цэргийн алба хааж байгаа сонгуулийн насны иргэдэд зориулан сонгох эрхийн асуудлаар эвхмэл хуудсыг боловсруулан 1200 ширхэг тус тус хэвлүүлж, ЗХЖШ-500, ХХЕГ-500, Дотоодын цэргийн штабт-200 ширхэгийг хүргүүлж тараасан.

Мөн Сонгуулийн Ерөнхий Хороо болон Сонгогчдын боловсрол төв, Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөн төрийн бус байгууллагуудтай хамтран “Зууны мэдээ”, “Үндэсний шуудан”, “Өөр мэдээ” өдөр тутмын сонингуудад “Иргэн төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй”; “Сонгогчийн боловсролд”; “Хариуцлагатай сонголтоор эрхээ баталгаажуулъя” сэдвээр сонгогчдын боловсролд зориулан мэдээлэл бэлдэж, нийтлэв.

Комиссын дарга Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар, Зэвсэгт Хүчний Жанжин Штаб, Хил Хамгаалах Ерөнхий Газар зэрэг байгууллагуудын төв болон орон нутгийн удирдах бүрэлдэхүүний цугларалтын үеэр сонгох, сонгогдох эрх, сонгуулийн бэлтгэл ажил, зохион байгуулалттай холбоотой асуудлаар 30-40 минутын мэдээлэл хийсэн.

“Хүртээмжтэй орчин 2012-Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгуулийн тэгш оролцоо” аяны байгууллагуудаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах чиглэлээр нэр дэвшигчид болон намууд мөрийн хөтөлбөр, сурталчилгааг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй хэлбэрээр хүргэх тухай гаргасан ил захидал болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сонгууль өгөх хүртээмжтэй орчин бүрдүүлэх тухай Сонгуулийн Ерөнхий Хороо, сонгуулийн тойрог, хэсгийн хороодод хандаж гаргасан зөвлөмжийг Комиссын цахим хуудаст байршуулах, Комиссын орон тооны бус зөвлөлийн гишүүд болон Комисстой хамтран ажилладаг төрийн байгууллага,

иргэний нийгмийн байгууллагууд, их, дээд сургуулийн багш, оюутнуудад цахим шуудангаар тус тус хүргүүлэв.

МҮОНТВ-тэй хамтран “Хүний эрх-Миний эрх” нэвтрүүлгийн №04-д иргэдийн сонгох эрхийг тусгайлан хөндөж, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх 25 минутын нэвтрүүлгийг бэлтгэн Монголын Үндэсний Телевизээр цацсан. Мэдээллийн эх сурвалжаар Хүний эрхийн Үндэсний Комисс болон Сонгуулийн Ерөнхий Хороо, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо зэрэг байгууллагын төлөөлөл оролцов. Сонгох, сонгогдох эрхийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжтэй орчны асуудлыг хөндсөн бөгөөд сонгуульд оролцох боломжтой бүх хүнийг сонгох эрхээ эдлэх боломжоор хангая гэсэн санааг энэхүү нэвтрүүлэгт тусгалаа.

Сонгогчдын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, сонгуулийн үйл ажиллагаатай мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэх зорилгоор Сонгогчдын боловсролын төвийн [www.2012.mn](http://www.2012.mn) цахим хуудсыг Комиссын цахим хуудаст линкээр холбоос хийж, мэдээллийг түгээв.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагуудтай хамтран “Хүртээмжтэй орчин” аяны хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сонгууль боломжийг бүрдүүлэх, санал авах байрыг энэхүү бүлэг бүхий иргэдэд хүртээмжтэй хэлбэрээр зохион байгуулах талаар асуудал хөндсөн хэвлэл мэдээллийн сурталчилгааг явуулж, эдгээр төрийн бус байгууллагын төлөөллийг ярилцлага, нэвтрүүлэгт зуучилж, хамтран ажиллалаа. “Өдрийн сонин”, “Үндэсний шуудан”, “Зууны мэдээ” зэрэг сонин, МҮОНТВ, ТВ9, ТВ5, MN-25 дугаар суваг зэрэг телевиз, МҮОНР-гийн “Хурд” агентлагаар дээрх асуудлыг хөндсөн мэдээ, мэдээллийг хийж, олон нийтэд хүргэв.

#### **Сонгуулийн санал өгөх үеэр хийх ажиглалтын чиглэлээр:**

ШШГЕГ-ын харьяа Цагдан хорих 0461 дүгээр анги болон НЦГ-ын Албадан саатуулах баривчлах төвд байгаа сонгогчид 2012 оны 6 дугаар сарын 27-ны өдөр зөөврийн битүүмжилсэн хайрцагаар санал өгөх үеэр Комиссын Ажлын албаны ажилтнууд сонгогчдын санал өгөх нөхцлийг хангасан эсэх, сонгогчид бусдын нөлөөнд орох, бусдад нөлөөлөхийг оролдож буй эсэх зөөврийн хайрцагаар санал авахад холбогдох хэсгийн хорооноос тавих хяналт, ажиглагчдыг оролцуулж буй байдал, санал өгөх иргэдийн тоог нарийвчлан тогтоон, дагаж мөрдөж буй эсэхэд ажиглалт хийлээ. Ажиглалтын үеэр тухайн объектуудад ямар нэгэн ноцтой зөрчил гараагүй бөгөөд захиргааны журмаар баривчлагдсан, албадан саатуулагдсан, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу баривчлагдсан, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан сонгогчдын санал өгөх байрыг хуульд заасны дагуу бэлтгэж, сонгуулийн саналыг авах үйл ажиллагааг хуулийн дагуу зохион байгууллаа. Эдгээр байгууллагууд нь сонгуулийн бэлтгэл ажлын сайтар хангахад өөрсдийн зүгээс санаачлагатай ажиллаж байсныг дурдах нь зүйтэй.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2012 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 333 дугаар албан бичгээр “хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж тусгайлан тоногдсон, нэгээс доошгүй тооны санал бэлтгэх бүхээгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй хэлбэрээр тоноглон засах, санал авах байруудын орц, гарцанд налуу зам байрлуулах ажлыг дотоод нөөц бололцоогоо ашиглан хийж гүйцэтгэх, санал авах бүхээгт сул хараатай сонгогчдод зориулсан томруулдаг шил байрлуулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг санал авах байранд ээлж, дараалал харгалзахгүйгээр оруулах” зэрэг асуудлаар ажлын чиглэл өгсөн.

Энэхүү чиглэлийн дагуу сонгон авсан тойргуудын хэсгийн хороодод хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан хүртээмжтэй орчин бүрдүүлсэн эсэхэд Мерси-Кор Монгол, “Хүртээмжтэй орчин 2012-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгуулийн тэгш оролцоо” аяны байгууллагуудтай хамтран Архангай, Өвөрхангай, Увс, Дархан, Дундговь, Баянхонгор аймаг, Нийслэлийн Сүхбаатар, Сонгинохайрхан, Баянгол, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн 101 хэсгийн хороодод ажиглалт, үнэлгээ хийв. Үүнээс Комисс дангаараа Хан-Уул, Багахангай, Багануур дүүргийн 21 дүгээр тойргийн 21 хэсгийн хороод, Чингэлтэй дүүргийн 24 дүгээр тойргийн 30 хэсгийн хороодод очиж ажиллан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сонгууль өгөх хүртээмжтэй орчин бүрдүүлсэн байдалтай газар дээр нь танилцаж, ажиллалаа.

2012 оны сонгуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй орчин бүрдүүлэхэд сонгуулийн зарим тойргийн хороо болон хэсгийн хороод санаачлагатай ажилласан гэж үзэхээр байна. Тухайлбал, Сонгуулийн Ерөнхий Хорооноос өгсөн чиглэлийн дагуу тойргийн хорооноос нэгдсэн журмаар харааны сул бэрхшээлтэй иргэдэд зориулан томруудаг шил тарааж өгснийг хэсгийн хороод хүлээн авч зарим хэсгийн хороод нэмэлтээр гэрэлтүүлэг тавих, өөрсдийн нөөц боломжоор налуу зам, гарцыг байршуулах, стандартын дагуу санал өгөх бүхээгийн хийх зэргээр тохижилтийн тодорхой ажлуудыг хийжээ. Харин зарим хэсгийн хороод байршил подваль болон 2-3 давхарт байрласан зэрэг нь тэргэнцэртэй, тулгуур эрхтний бэрхшээлтэй иргэд өөрсөө ирж саналаа өгөх боломж бүрдсэн гэж үзэхэд учир дутагдалтай байсан. Ерөнхийдөө хэсгийн хороод тухайн хорооны нийгмийн ажилтны гаргасан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгааг үндэслэн зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал авахаар төлөвлөсөн тухай нийтлэг танилцуулж байлаа.

“Хүртээмжтэй орчин 2012-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгуулийн тэгш оролцоо” аяны байгууллагуудтай хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сонгууль өгөх хүртээмжтэй орчин бүрдүүлсэн байдалд хийсэн ажиглалт, үнэлгээний тайланг талуудтай нэгтгэн боловсруулж байна.

**Сонгуулийн үеэр илэрсэн зөрчил дутагдал, түүнийг арилгах талаар авсан зарим арга хэмжээний талаар:**

Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газар болон Цагдаагийн Ерөнхий Газраас захиргааны журмаар баривчлагдсан, албадан саатуулагдсан, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу баривчлагдсан, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан сонгогчдын хөдөлгөөний өөрчлөлттэй холбоотой судалгааг цаг тухай бүр Сонгуулийн ерөнхий хороо болон Хүний эрхийн Үндэсний Комисст ирүүлж ажиллалаа.

ШШГЕГ-аас өгсөн сонгуулийн насны санал өгөх иргэдийн судалгаатай танилцаж үзвэл:

д/д	Сонгуулийн насны иргэдийн судалгаа	IV/27	V/31	VI/18	VI/27 буюу зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал өгсөн иргэдийн тоо
1	Аймаг, нийслэлийн Цагдан хорих байранд хоригдож байгаа сонгуулийн насны иргэд	880	863	414	
2	Аймаг, нийслэлийн Цагдан хорих байрны хүлээлгэнд хоригдож байгаа сонгуулийн насны иргэд	566	584	229	



3	Нийт санал өгөх иргэдийн тоо	1446	1447	643	417
4	ШШГЕГ-ын харьяа Цагдан хорих 461 дүгээр анги	762	734	225	108

ШШГЕГ-ын харьяа Цагдан хорих 461 дүгээр анги, байршиж байгаа сонгуулийн 25 дугаар тойргийн 50 дугаар хэсгийн хорооноос тус цагдан хорих байранд байгаа сонгуулийн насны иргэдийн нэрийн жагсаалтыг хуульд заасан хугацаа буюу 5-аас доошгүй хоногийн өмнө ирүүлснээр тооцохгүй урьд ирүүлсэн 6 дугаар сарын 18-ны өдрийн нэрийн жагсаалтаар сонгууль өгүүлнэ гэж шийдвэрлэсэн нь тухайн хөдөлгөөнтэй бүст байгаа сонгуулийн санал өгөх иргэдийн нэрийн жагсаалт бодитой гарахгүй нөхцөл байдал үүссэн. Энэ талаар Комисс, ШШГЕГ, СЕХ-ны удирдлагуудад танилцуулсны үндсэн дээр сонгогчдын нэрийн жагсаалтад санал өгөх өдрийн өмнөх өдөр дахин тулгалт хийж, тус цагдан хорих байрны санал өгөх иргэдийн нэрийн жагсаалтад дахин тулгалт хийж шийдвэрлэв.

ШШГЕГ-ын харьяа Цагдан хорих 461 дүгээр ангид зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал өгөх өдөр нийт 110 сонгогч санал өгөхөөр нэрийн жагсаалтад бүртгэгдсэнээс 1 сонгогч хорих ангид шилжиж, 1 сонгогч шүүх хуралд оролцохоор явж, нийт 108 сонгогч саналаа өглөө. Тус ангийн зүгээс иргэний бичиг баримтгүй, лавлагаатай иргэдийн мэдээллийг Улсын Бүртгэлийн Ерөнхий Газарт цаг тухайд нь хүргүүлсэн хэдий ч цахим үнэмлэхийг тухайн иргэнд өөрт нь өгнө гэсэн шийдвэрийг бүртгэлийн байгууллагаас гаргаснаас ангийн захиргаа цагдан хоригдсон, баривчлагдсан иргэдийн цахим үнэмлэхийг авч чадахгүй болжээ. Мөн зарим цагдан хоригдсон, баривчлагдсан иргэдийн иргэний үнэмлэхийг хичнээн хөөцөлдөөд ч ар гэрээс нь авчирч өгөөгүй бөгөөд сонгууль өгөхгүй гэж өөрсдөө хүсэлт гаргасан зарим сонгогчид байгаа тухай тус ангийн нийгмийн ажилтан танилцууллаа.

#### Шигтгээ 1

...Төв аймгийн цагдах хорих байранд яллагдагчаар татагдан цагдан хоригдож байсан Ашигт малтмалын газрын дарга асан Б.Батхуягийг 2012 оны 6 дугаар сарын 22-ны өдөр буюу зөөврийн хайрцгаар санал өгөх өдрөөс 5 хоногийн өмнө Зүүнхараагийн цагдан хорих байранд шилжүүлэн хорих шүүхийн шийдвэр гарчээ. Хууль хяналтын байгууллагын эрх бүхий албан тушаалтнууд Сонгуулийн тухай хуульд заасан сонгогч шилжих, зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал өгөх хүсэлт гаргах зэрэг хуулийн хугацааг харгалзаж үзэхгүйгээр цагдан хоригдож байгаа сонгогчийн шилжүүлэн хорих шийдвэр гаргаснаас тухайн сонгогч сонгох эрхээ эдэлж чадаагүй байна.

Цагдаагийн Ерөнхий Газраас ирүүлсэн аймаг, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэст түр болон албадан саатуулагдсан, шүүхийн шийдвэрээр баривчлагдсан иргэдийн судалгаатай танилцахад 6 дугаар сарын 25-ны байдлаар нийт 119 сонгуулийн насны иргэн байгаагаас 6 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд гарах иргэдийн хассанаар нийт 75 иргэн санал өгөхөөр байна.

Нийслэлийн Цагдаагийн Газрын Албадан саатуулах баривчлах төвөөс зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал өгөх 85 иргэдийн нэрийн жагсаалтыг сонгуулийн 24 дүгээр тойргийн 25 дугаар хэсгийн хороонд хүргүүлсэн боловч тус хэсгийн хорооноос 71 иргэн сонгууль өгнө, харин хөдөө орон нутгаас ирсэн 12 иргэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль давхар явагдаж байгаа учраас сонгууль өгөхгүй гэсэн шийдвэр гаргаснаар эдгээр иргэдийн сонгох эрх зөрчигдөж, сонгууль өгч чадаагүй байна. Мөн 2 иргэн бичиг баримтгүй, цахим үнэмлэх аваагүй гэсэн

шалтгаанаар сонгууль өгөх боломжгүй болжээ. Тус төвд зөөврийн битүүмжилсэн хайрцгаар нийт 68 иргэн санал өгсөн бөгөөд нэрийн жагсаалтаар 71 иргэн санал өгөхөөр байсан ч 3 иргэн суллагдсан учир зөөврийн битүүмжилсэн хайрцгаар сонгууль өгөөгүй болно.

Зэвсэгт Хүчний Жанжин Штаб, Хил Хамгаалах Ерөнхий Газар, Дотоодын цэргийн штаб нь цэргийн алба хаагчдын мэдээлэл нууцын зэрэглэлд байдаг учраас танайд сонгуулийн насны санал өгөх хугацаат болон гэрээт цэргийн алба хаагчдын талаарх мэдээллийг албан бичгээр хүргүүлэх боломжгүй гэж мэдэгдсэн. Иймд хугацаат болон гэрээт цэргийн алба хаагчдын иргэний үнэмлэхийг ар гэрээс нь татаж авах, лавлагааны хуудастай цэрэгт татагдсан алба хаагчдын судалгааг утсаар холбогдон авч, ажиллалаа.

д/д	Байгууллагууд	Сонгуулийн өмнө		Сонгууль өгөх үеэр	
		Шинээр цахим үнэмлэх авах, лавлагааны хуудастай	Бичиг баримтын зөрчилтэй, Иргэний үнэмлэхийг ар гэрээс нь авах	Шинээр цахим үнэмлэх авах, лавлагааны хуудастай	Бичиг баримтын зөрчилтэй, Иргэний үнэмлэхийг ар гэрээс нь авах
1	ЗХЖШ-ын харьяа цэргийн ангиуд			3	
2	ХХЕГ-ын харьяа хилийн цэргийн ангиуд	176	81	33	41
3	Дотоодын цэргийн штаб	58		58	

Шинээр цахим үнэмлэх авах, лавлагаатай цэргийн алба хаагчдын мэдээллийг Улсын Бүртгэлийн Ерөнхий Газарт Дотоодын цэргийн штабаас 5 дугаар сарын 16-ны өдөр, Хил Хамгаалах Ерөнхий Газраас 5 дугаар сарын 30-ны өдөр тус тус хүргүүлжээ. Гэвч Улсын Бүртгэлийн Ерөнхий Газраас цэргийн алба хаагчдын цахим үнэмлэхийг Хил Хамгаалах Ерөнхий Газар болон Дотоодын цэргийн штабт хүргэлгүйгээр хуучин хаягаар тойрог хэсгийн хороодод хүргэсэн нь хүндрэл үүсгэж, аймаг орон нутгийн цэргийн штабаар дамжуулан хугацаат болон гэрээт цэргийн алба хаагчдын цахим үнэмлэхийг авч ангиуд руу нь шилжүүлэх арга хэмжээг авч ажиллажээ.

### Шигтгээ 2

... Дотоодын цэргийн штабаас Булган аймгийн тойргийн хорооны хэсгийн хороонд хүргэгдсэн хугацаат цэргийн цахим үнэмлэхийг сонгууль өмнөх өдөр хөөцөлдөж байж авсан....

/Дотоодын цэргийн штабын дарга, бригадын генерал Т.Хүрэлбаатартай хийсэн ярилцлагаас/

### Шигтгээ 3

... Хил Хамгаалах Ерөнхий Газарт Дорнод аймгийн Халхгол сумын хилийн 0198 дугаар цэргийн ангийн хугацаат цэргийн алба хаагчдын шинээр цахим үнэмлэхийг сонгуулийн өмнөх өдрүүдэд өгсөн нь цаг хугацааны хувьд шуудангаар хүргэх ямар ч боломжгүй байдалд хүрчээ.

Зэвсэгт Хүчний Жанжин Штабаас өгсөн мэдээллээр цэрэг татлагаар иргэний бичиг баримттай залуусыг бүртгэж авсан нь бичиг баримттай холбоотой зөрчил дутагдал харьцангуй бага гарсан байна. Харин Зэвсэгт Хүчний Жанжин Штабын харьяа нэг ангид туршилтын санал өгөх үйл ажиллагааг зохион байгуулахад 104 цэрэг санал өгснөөс 99 цэрэг санал өгөх боломжтой, үлдсэн 5 цэргийн хурууны хээ олдохгүй байна гэсэн шалтгаанаар санал өгөх боломжгүй байдалд хүрчээ. Гэвч сонгуулийн санал өгөх өдөр Зэвсэгт Хүчний Жанжин Штабын харьяа анги байгууллагуудаас сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой ямар нэгэн гомдол, санал гараагүй болохыг ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын орлогч дарга, хурандаа Б.Эрхэмбаяр мэдэгдлээ.

#### Шигтгээ 4

Сонгуулийн Ерөнхий Хорооноос НҮБ-ын Аюулгүйн зөвлөл, Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр энхийг дэмжих ажиллагаанд оролцохоор явж байгаа 317 цэргийн алба хаагч нь 2012 оны УИХ-ын болон ИТХ-ын сонгуульд саналаа өгөх боломжгүйг мэдэгдсэн нь хүний эрхийн тэр дундаа сонгох эрхийг зөрчсөн ноцтой зөрчил боллоо. Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэхээр явж байгаа эдгээр цэргийн алба хаагчдын хувьд Хойд Судан, Өмнөд Судан болон Афганистан улс орнуудад Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газар байхгүй болон зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал авах өдрийн өмнөх өдөр байхаар хуульчилсан зэргээс шалтгаалан сонгох эрхээ эдлэх боломжгүй болсон. Сонгууль зарласан, сонгуульд оролцох нам, мөн нэр дэвшигчид тодорхой болсон байхад иргэд сонгуульд оролцох ёстой ч өөрсдөөс үл шалтгаалах нөхцөл байдлаас хамаарч саналаа урьдчилж өгөхийг хуулиар хаасан тул цаашид ийм төрлийн зөрчлийг арилгах эрх зүйн зохицуулалт бий болгоход Комиссоос анхаарч ажиллах талаар Зэвсэгт Хүчний Жанжин Штабт мэдэгдэв.

Улсын Бүртгэлийн Ерөнхий Газраас шинээр цахим үнэмлэх авах иргэдийн тоо нэмэгдэж 64000 болсон тухай Улсын Их Хуралд танилцуулж, эдгээр иргэдэд цахим үнэмлэх олгох ажлыг сонгууль өгөх өдрөөс өмнө хэвлэж тараахаар шийдвэрлэсэн билээ. Шинээр цахим үнэмлэх авах иргэдийн тоо 5 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар 64000, 6 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар 104000 болж нэмэгдсэн байна. Сонгуулийн санал өгөх өдөр буюу 6 дугаар сарын 28-ний өдрийг хүртэл хугацаанд УБЕГ-аас нийт 104000 иргэний цахим үнэмлэхийг хэвлэн түгээжээ. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр шинээр иргэний цахим үнэмлэх хэвлэх, түгээхтэй холбоотой багагүй зөрчил гарч байгаа тухай мэдээлж байлаа. Тухайлбал, хуучин иргэний үнэмлэхтэй хүн, давхар шинээр цахим үнэмлэх олгогдох, хаяг байршил солигдож, өөр хэсгийн хороодод шилжсэнээр сонгогчдын нэрийн жагсаалтаас хасагдах, мөн цэрэгт татагдсан залуусын цахим үнэмлэх цэргийн анги байгууллагад нь бус сонгуулийн тойргийн хэсгийн хороодод хуучин хаягаар хүргэгдэх зэрэг асуудлууд гарчээ.

#### **Дүгнэлт, санал, зөвлөмж:**

2012 оны Улсын Их Хурлын болон Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг нэг өдөр зохион байгуулахаар шийдвэрлэн урьд өмнөх сонгуулийн үеэр гарч байсан зөрчлийг гаргуулахгүй байхад анхаарч, Улсын Их Хурлаас хууль, эрх зүйн орчныг шинэчлэх, сонгуулийн бэлтгэл ажил, зохион байгуулалтын үйл ажиллагааг сонгуулийн төв байгууллага, сонгуулийн үйл ажиллагаанд оролцох төрийн чиг үүрэг бүхий байгууллагууд болон төрийн бус байгууллагууд хамтран хэрэгжүүлсэн нь ач холбогдолтой байлаа.



Зэвсэгт Хүчний Жанжин Штабаас өгсөн мэдээллээр цэрэг татлагаар иргэний бичиг баримттай залуусыг бүртгэж авсан нь бичиг баримттай холбоотой зөрчил дутагдал харьцангуй бага гарсан байна. Харин Зэвсэгт Хүчний Жанжин Штабын харьяа нэг ангид туршилтын санал өгөх үйл ажиллагааг зохион байгуулахад 104 цэрэг санал өгснөөс 99 цэрэг санал өгөх боломжтой, үлдсэн 5 цэргийн хурууны хээ олдохгүй байна гэсэн шалтгаанаар санал өгөх боломжгүй байдалд хүрчээ. Гэвч сонгуулийн санал өгөх өдөр Зэвсэгт Хүчний Жанжин Штабын харьяа анги байгууллагуудаас сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой ямар нэгэн гомдол, санал гараагүй болохыг ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын орлогч дарга, хурандаа Б.Эрхэмбаяр мэдэгдлээ.

#### Шигтгээ 4

Сонгуулийн Ерөнхий Хорооноос НҮБ-ын Аюулгүйн зөвлөл, Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр энхийг дэмжих ажиллагаанд оролцохоор явж байгаа 317 цэргийн алба хаагч нь 2012 оны УИХ-ын болон ИТХ-ын сонгуульд саналаа өгөх боломжгүйг мэдэгдсэн нь хүний эрхийн тэр дундаа сонгох эрхийг зөрчсөн ноцтой зөрчил боллоо. Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэхээр явж байгаа эдгээр цэргийн алба хаагчдын хувьд Хойд Судан, Өмнөд Судан болон Афганистан улс орнуудад Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газар байхгүй болон зөврийн битүүмжилсэн хайрцагар санал авах өдрийн өмнөх өдөр байхаар хуульчилсан зэргээс шалтгаалан сонгох эрхээ эдлэх боломжгүй болсон. Сонгууль зарласан, сонгуульд оролцох нам, мөн нэр дэвшигчид тодорхой болсон байхад иргэд сонгуульд оролцох ёстой ч өөрсдөөс үл шалтгаалах нөхцөл байдлаас хамаарч саналаа урьдчилж өгөхийг хуулиар хаасан тул цаашид ийм төрлийн зөрчлийг арилгах эрх зүйн зохицуулалт бий болгоход Комиссоос анхаарч ажиллах талаар Зэвсэгт Хүчний Жанжин Штабт мэдэгдэв.

Улсын Бүртгэлийн Ерөнхий Газраас шинээр цахим үнэмлэх авах иргэдийн тоо нэмэгдэж 64000 болсон тухай Улсын Их Хуралд танилцуулж, эдгээр иргэдэд цахим үнэмлэх олгох ажлыг сонгууль өгөх өдрөөс өмнө хэвлэж тараахаар шийдвэрлэсэн билээ. Шинээр цахим үнэмлэх авах иргэдийн тоо 5 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар 64000, 6 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар 104000 болж нэмэгдсэн байна. Сонгуулийн санал өгөх өдөр буюу 6 дугаар сарын 28-ний өдрийг хүртэл хугацаанд УБЕГ-аас нийт 104000 иргэний цахим үнэмлэхийг хэвлэн түгээжээ. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр шинээр иргэний цахим үнэмлэх хэвлэх, түгээхтэй холбоотой багагүй зөрчил гарч байгаа тухай мэдээлж байлаа. Тухайлбал, хуучин иргэний үнэмлэхтэй хүн, давхар шинээр цахим үнэмлэх олгогдох, хаяг байршил солигдож, өөр хэсгийн хороодод шилжсэнээр сонгогчдын нэрийн жагсаалтаас хасагдах, мөн цэрэгт татагдсан залуусын цахим үнэмлэх цэргийн анги байгууллагад нь бус сонгуулийн тойргийн хэсгийн хороодод хуучин хаягаар хүргэгдэх зэрэг асуудлууд гарчээ.

#### **Дүгнэлт, санал, зөвлөмж:**

2012 оны Улсын Их Хурлын болон Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг нэг өдөр зохион байгуулахаар шийдвэрлэн урьд өмнөх сонгуулийн үеэр гарч байсан зөрчлийг гаргуулахгүй байхад анхаарч, Улсын Их Хурлаас хууль, эрх зүйн орчныг шинэчлэх, сонгуулийн бэлтгэл ажил, зохион байгуулалтын үйл ажиллагааг сонгуулийн төв байгууллага, сонгуулийн үйл ажиллагаанд оролцох төрийн чиг үүрэг бүхий байгууллагууд болон төрийн бус байгууллагууд хамтран хэрэгжүүлсэн нь ач холбогдолтой байлаа.



2012 оны сонгуулийн ирц урьд өмнөх сонгуулийн ирцээс багагүй буурсан үзүүлэлт гарсан хэдий ч эрх зүйн шинэ орчинд сонгуулийг явуулсан нь зарчмын хувьд тодорхой ахиц дэвшил гарсан гэж үзэхээр байна. Тухайлбал, автоматжуулсан системээр саналыг хуудсыг тоолох, гадаадад амьдарч байгаа монголчууд саналаа өгөх боломжийг бүрдүүлэх, нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгаатай холбоотой болон сонгогчдод зориулсан хориглосон, зөвшөөрсөн зохицуулалтыг тодорхой зааж өгөх, сонгуулийн үйл ажиллагааг төрийн алба хаагчид зохион байгуулах, тэдгээрт хүлээлгэх хариуцлагын механизмыг тодорхойлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сонгууль өгөх хүртээмжтэй орчинг бүрдүүлэх эрх зүйн орчин бий болгосныг дурдаж болно. Мөн Сонгуулийн Ерөнхий Хороотой сонгуулийн бүхий л үйл ажиллагаанд хөндлөнгийн ажиглалт хийхээр 11 төрийн бус байгууллага гэрээ байгуулж, хамтран ажилласан нь шинэлэг үйл ажиллагаа боллоо.

Сонгуулийн санал өгөх өдөр хэвлэл мэдээллийн хэрэгслээр уул уурхайн томоохон компаниуд ажилчдынхаа сонгох эрхийг хангаж ажиллагаагүйгээс саналаа өгч чадаагүй олон мянган иргэд байна (жишээ нь: Оюу толгой, Энержи ресурс компаниуд 2000-3000, 3000-4000) гэсэн асуудал хөндөгдөж байв. Мөн сонгогчдын нэрийн жагсаалтаас тухайн хаягт байнга оршин суудаг иргэдийн нэр, хаяг өөрчлөгдснөөс сонгуулиа өгч чадахгүй байгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээллэж байлаа.

Комисс нь Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх ээлжит итгэлдээ сонгууль нь бүх нийтийн байх зарчмын хүрээнд цаашдын сонгуульд сонгуулийн ирцийг сайжруулах өөрөөр хэлбэл иргэдийн сонгох эрх эдлэх боломжийг бүрдүүлэх талаар хөндөж бичих нь зүйтэй байна.

Иргэдийн өөрсдөөс нь үл шалтгаалах байдлаар сонгох эрхийг хуулиар хаасан, хязгаарласан хуулийн зохицуулалтад хүний эрхийн үүднээс дүн шинжилгээ хийх, дээрх төрийн бус байгууллагуудын тайлангаас иргэдийн сонгох эрхийг зөрчсөн асуудлыг судлан баримтжуулж, Комиссоос хийсэн энэхүү мониторингийн дүн, цугларсан кейс, баримтад дүгнэлт хийх, мөн уул уурхайн компаниуд нийгмийн хариуцлагаа ухамсарлан ажилчдынхаа сонгох эрхийг хангах асуудалд анхаарч ажиллах тухай тодорхой санал, зөвлөмж дэвшүүлэн илтгэлдээ тусгаж бичих саналыг гаргаж байна.

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

## ИЛТГЭХ ХУУДАС

2012 оны 06 дугаар сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

ХЭҮК-оос иргэдийн сонгох эрхийн хэрэгжилтэд хийж буй мониторингийн удирдамжийн дагуу Монгол Улсын Их Хурлын болон Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийг зохион байгуулж явуулахдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэгш эрхийн оролцоог хангах, Үндсэн хууль, олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцоор баталгаажсан сонгох эрхийг хангах үүднээс Хан-Уул, Багахангай, Багануур дүүргийн сонгуулийн 21 дүгээр тойргийн хэсгийн 21 хороодод дараах байдлаар ажиглалт хийлээ.

- УИХ-ын сонгуулийн хэсгийн хорооны болон санал авах байрыг бэлтгэхдээ зааврын 3 дугаар зүйлийн 3.3.3-т заасан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж тоногосон, нэгээс доошгүй тооны санал бэлтгэх бүхээ”-г хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй хэлбэрээр тоноглох засах, санал авах байруудын орц, гарцанд налуу зам байрлуулсан эсэх
- Санал бэлтгэх бүхээгт сул хараатай сонгогчдод зориулан томруулдаг шил байрлуулсан эсэх
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ байршуулсан эсэх.

### **7 дугаар хэсгийн хороо**

Гадна, дотно зөөврийн налуу шаттай. Томруулдаг харааны шилтэй. Зөөврийн битүүмжилсэн хайрцгаар 13 иргэн саналаа өгнө. Тэргэнцэртэй 6 иргэн, нийт хөгжлийн бэрхшээлтэй 218 иргэн байгаа.

### **8 дугаар хэсгийн хороо**

Гадна шат нь стандартын дагуу налуу шаттай. Санал авах байр нь 3 давхарт байгаа учир тэргэнцэртэй иргэн явах боломжгүй. Зөөврийн хайрцгаар 11 хүн саналаа өгнө. Томруулдаг шилтэй. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тусгайлсан зориулалтын санал өгөх бүхээг байхгүй.

### **9 дүгээр хэсгийн хороо**

Зөөврийн хайрцгаар 3 иргэн санал өгнө, томруулдаг шилтэй. гадна шат стандартын дагуу. Санал авах байр нь 2 давхарт учир хөгжлийн бэрхшээлтэй иргэн санал өгөх боломжгүй. Зориулалтын санал өгөх бүхээг байхгүй.

### **10 дугаар хэсгийн хороо**


Гадна дотно зориулалтын налуу шаттай, Зөөврийн битүүмжилсэн хайрцгаар 10 хүн санал өгнө. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн зориулсан тусгайлсан санал өгөх бүхээгтэй.

### **11 дүгээр хэсгийн хороо**

Гадна, дотно налуу шатгүй, Санал өгөх байр 2 давхарт байрласан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн зориулсан тусгайлсан санал өгөх бүхээгтэй. Сул хараатай иргэдэд зориулсан гэрэл, томруулдаг шилтэй. Зөөврийн битүүмжилсэн хайрцгаар 19 иргэн саналаа өгнө.

### **12 дугаар хэсгийн хороо**

Гадна налуу шаттай, дотор байран стандартын дагуу тэргэнцэртэй иргэдэд зориулсан шатны бариултай. Санал өгөх зориулалтын бүхээг байхгүй. Зөөврийн хайрцгаар 24 иргэн санал өгнө. Томруулдаг шилтэй.



### **15 дугаар хэсгийн хороо**

Зөөврийн налуу шат хийж байгаа. Санал авах байр 3 давхарт байрласан. Санал өгөх зориулалтын бүхээг байхгүй. Зөөврийн хайрцгаар 11 хүн саналаа өгнө. Томруулдаг шил байгаа.

### **17 дугаар хэсгийн хороо**

Зөөврийн хайрцгаар 13 иргэн санал өгнө. Томруулдаг шил байгаа. Санал өгөх зориулалтын бүхээг байхгүй. Налуу шат байхгүй.

### **18 дугаар хэсгийн хороо**

Гадна, дотно налуу шат, зориулалтын бариултай. Тэргэнцэртэй иргэн санал өгөх бүхээггүй. Санал авах байр нь подвальд байрласан. Томруулдаг шилтэй. Зөөврийн хайрцгаар 12 иргэн саналаа өгнө.

### **19 дүгээр хэсгийн хороо**

Гадна, дотно налуу шаттай. Санал өгөх зориулалтын бүхээг байхгүй. Томдруулдаг шилтэй. Зөөврийн хайрцгаар 13 иргэн саналаа өгнө.

### **20 дугаар хэсгийн хороо**

Зөөврийн хайрцгаар 2 иргэн саналаа өгнө. Томруулдаг шилтэй. Санал өгөх зориулалтын бүхээггүй, налуу шат байхгүй.

### **21 дүгээр хэсгийн хороо**

Налуу шат байхгүй. Хөгжлийн бэрхшээлтэй 167 иргэн байгаа. Томруулдаг шилтэй, Санал өгөх зориулалтын бүхээг байхгүй. Зөөврийн хайрцгаар 7 иргэн саналаа өгнө.

### **23 дугаар хэсгийн хороо**

Санал өгөх зориулалтын бүхээггүй, гадна, дотно налуу шатгүй. Томдруулдаг шилтэй, Зөөврийн хайрцгаар 27 иргэн саналаа өгнө.

### **25 дугаар хэсгийн хороо**

Санал өгөх зориулалтын бүхээггүй. Томруулдаг шилтэй. Нэг давхарт шат байхгүй. Зөөврийн хайрцгаар 8 иргэн санлаа өгнө.

### **28 дугаар хэсгийн хороо**

Гадна налуу шаттай, Хөгжлийн бэрхшээлтэй 7 иргэн байгаа. Санал өгөх зориулалтын бүхээг байхгүй. Томруулдаг шилтэй. Зөөврийн хайрцгаар 14 иргэн саналаа өгнө.

### **29 дүгээр хэсгийн хороо**

Гадна налуу шаттай. Томруулдаг шилтэй. Санал өгөх зориулалтын бүхээг байхгүй. Санал өгөх байр 2 давхарт байрласан. Зөөврийн хайрцгаар 13 иргэн саналаа өгнө.

### **30 дугаар хэсгийн хороо**


Налуу шат байхгүй. Санал өгөх зориулалтын бүхээг байхгүй. Томруулдаг шилтэй. Зөөврийн хайрцгаар 12 иргэн саналаа өгнө.

### **32 дугаар хэсгийн хороо**

Санал авах байр 2 давхарт байрласан, намуу шат байхгүй, санал өгөх зориулалтын бүхээг байхгүй. Зөөврийн хайрцгаар 10 иргэн саналаа өгнө. Томруулдаг шилтэй.

### **36 дугаар хэсгийн хороо**

Налуу шатгүй, санал өгөх зориулалтын бүхээггүй. Хөгжлийн бэрхшээлтэй 125 иргэн байгаа. Зөөврийн хайрцгаар 11 хүн саналаа өгнө. Томруулдаг шилтэй.





### **37 дугаар хэсгийн хороо**

Подвольд байрлалтай, налуу шатгүй, санал өгөх зориулалтын бүхээг байхгүй. Томруулдаг шилтэй. Зөөврийн хайрцгаар 17 иргэн саналаа өгнө.

#### **Дүгнэлт:**

Тус тойргийн хэсгийн хороодод хөгжлийн бэрхшээлтэй иргэнд сонгууль өгөх хүртээмжтэй орчин бүрдүүлэх талаар зарим хэсгийн хороод тодорхой ажлуудыг хийсэн байна.

Ерөнхийдөө нийтлэг байдлаар хэсгийн хороод хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ судалгааг нарийвчлан гаргаж, өөрсдөө ирж саналаа өгөх үү, зөөврийн битүүмжилсэн хайрцгаар саналаа өгөх үү гэдгийг тодруулж үзсэний үндсэн дээр санал өгөх байрыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сонгууль өгөх боломжийг бүрдүүлэхэд анхаарч ажилласан гэж үзэхээр байна.

Сонгуулийн ерөнхий хорооноос хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй орчин бүрдүүлэх талаар өгсөн чиглэлийн дагуу нэн тэргүүнд сул хараатай иргэдэд зориулан томруулдаг шил, нэмэлт гэрэлтүүлэг тавих ажлыг хийсэн байна. Санал өгөх зориулалтын тусгайлсан бүхээгийг стандартын дагуу хийсэн 2 хэсгийн хороо байсан бол зөөврийн налуу шат, замыг зарим хэсгийн хороод өөрсдийн нөөц боломжид тулгуурлан хийсэн байна.

## Илтгэх хуудас

2012-оны 06 дугаар сарын 26 өдөр

Улаанбаатар хот

ХЭҮК-оос иргэдийн сонгох эрхийн хэрэгжилтэнд хийж буй мониторингийн удирдамжийн дагуу Монгол Улсийн Их Хурлын болон Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийг зохион байгуулж явуулахдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэгш эрхийн оролцоог хангах үүднээс Чингэлтэй дүүргийн сонгуулийн 24 дүгээр тойргийн 16-44 дүгээр хэсгийн хороодод дараах байдлаар ажиглалт хийлээ.

1. УИХ-ын сонгуулийн хэсгийн хорооны болон санал авах байрыг зааврын 3 дугаар зүйлийн 3.3.3т заасан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж тоногдсон нэгээс доошгүй тооны санал бэлтгэх бүхээг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй хэлбэрээр тоноглох, засах санал авах байруудыг орц ,гарцанд налуу зам байрлуулсан эсэх

2. Санал бэлтгэх бүхээгт сул хараатай сонгогчидод зориулан томруулдаг шил байрлуулсан эсэх

3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ байршуулсан эсэх

**16 дугаар хэсгийн хороо** нь 1 давхарт байрлаж байв. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд орох, гарахад зориулагдсан налуу зам байхгүй байлаа.

Хөгжлийн бэрхшээлтэй 117 иргэн байдгаас 13 нь сул харааны бэрхшээлтэй, 2 нь суга таягтай.

Сул хараатай иргэдэг зориулан томруулдаг шил 1 ширхэгийг сонгуулийн тойргийн хорооноос өгсөн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан тусгайлан тоногдсон санал авах бүхээг байхгүй байв.

**18 дугаар хэсгийн хороо** нь 1 давхарт байрлаж байв. Налуу замтай.

Сул хараатай иргэдэг зориулан томруулдаг шил 1 ширхэгийг сонгуулийн тойргийн хорооноос өгсөн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй 23 иргэн байдгаас 22 иргэн зөөврийн хайрцагаар саналаа өгч, 1 тэргэнцэртэй иргэн сонгуулийн байран дээр ирж саналаа өгнө.

**19 дүгээр хэсгийн хороо** нь 2 давхарт байрлаж байв. Налуу замгүй.

2 харааны бэрхшээлтэй иргэн байдгаас 1 иргэн нь өөрийн биеэр ирж саналаа өгнө. 1 иргэн нь итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй ирж саналаа өгнө.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу шатны тухайд хийж, байршуулах хөрөнгө мөнгө байхгүй хэмээн сургуулийн болон хэрсгийн хорооны захирал Энхсайхан тайлбарлаж байв.

Сул хараатай иргэдэг зориулан томруулдаг шил 1 ширхэгийг сонгуулийн тойргийн хорооноос өгсөн байна.

**20 дугаар хэсгийн хороо** нь Чингэлтэй дүүргийн 57 дугаар сургуулийн нэг давхарт байрлаж байв.Налуу замгүй.

Хөгжлийн бэрхшээтэй хэвтэрийн 9 иргэн, харааны сул бэрхшээлтэй 1 иргэн зөөврийн хайрцгаар саналаа өгнө.

Сул хараатай иргэдэг зориулан томруулдаг шил 1 ширхэгийг сонгуулийн тойргийн хорооноос өгсөн.

**26 дугаар хэсгийн хороо** нь Чингэлтэй дүүргийн 17 дугаар сургуулийн 3 давхарт байрладаг учраас налуу шатны хүндрэл их байгаа хэмээн хэсгийн хорооны дарга Дэжид тайлбарлаж байв.

Хөгжлийн бэрхшээлтэй 4 иргэн байгаа.

Сул хараатай иргэдэг зориулан томруулдаг шил 1 ширхэгийг сонгуулийн тойргийн хорооноос өгсөн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан тусгайлан тоногловсон санал бэлтгэх бүхээг байхгүй байв.

**28 дугаар хэсгийн хороо** нь 1 давхарт байрлаж байв.Налуу замгүй.

Хөгжлийн бэрхшээлтэй 18 иргэн байгаагаас 2 нь харааны сул бэрхшээлтэй, бусад нь хэвтэрийн болон хүнд өвчтэй хүн байгаа.

Зөөврийн хайрцгаар саналаа өгөх учир хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан тусгайлан тоногловсон санал бэлтгэх бүхээс байршуулах хэрэггүй хэмээн үзэж байгаа гэж дарга Эрдэнэ-туул тайлбарлаж байв.

**30 дугаар хэсгийн хороо** нь 1 давхарт байрлаж байв.Налуу замтай.

Хөгжлийн бэрхшээлтэй 3 иргэн байгаа. Зөөврийн хайрцгаар санал өгөх 16 иргэн байгаа.

Сул хараатай иргэдэг зориулан томруулдаг шил 1 ширхэгийг сонгуулийн тойргийн хорооноос өгсөн байна.

**31 хэсгийн хороо** нь 2 давхарт байрлаж байв. Гаднаа налуу замтай.

Хөгжлийн бэрхшээлтэй 243 иргэн байгаагаас 4 иргэн нь ирж саналаа өгнө.

Бусад хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь зөөврийн хайрцгаар саналаа өгнө.

Сул хараатай иргэдэд зориулан томруулдаг шил 1 ширхэгийг сонгуулийн тойргийн хорооноос өгсөн байна.



**32 дугаар хэсгийн хороо** нь 0 давхарт байрлаж байв Налуу зам байхгүй.

Хөгжлийн бэрхшээлтэй 303 иргэн байгаагийн 2 буюу 1% нь сонгуулийн насны иргэн байгаа.

Зөөврийн хайрцгаар санал өгөх үеэр 28 хүний бүрэлдэхүүнтэй баг ажиллана.

Сул хараатай иргэдэг зориулан томруулдаг шил 1 ширхэгийг сонгуулийн тойргийн хорооноос өгсөн байна.

**33 дугаар хэсгийн хороо** нь 1 давхарт байрлаж байв.Налуу замгүй.

Хорооныхоо нийгмийн ажилтан болон эмнэлэгийн акттай тохируулснаас хөгжлийн бэрхшээлтэй 9 хүн байгаагийн 8 нь зөөврийн хайрцгаар, 1 нь өөрийн биеэр ирж санал өгөх ба цагдаагийн ажилтантайгаа хамтраад өргөж оруулах бодолтой ажиллаж байна хэмээн хорооны дарга Янжиндулам тайлбарлаж байв.

Сул хараатай иргэдэг зориулан томруулдаг шил 1 ширхэгийг сонгуулийн тойргийн хорооноос өгсөн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгайлан тоноглогсон санал авах бүхээг байхгүй байв.

**39 дүгээр хороо** нь 1 давхарт байрлаж байв. Налуу замтай.

Хөгжлийн бархшээлтэй 2 тэргэнцэртэй иргэн байгаа, 1 иргэн сул харааны бэрхшээлтэй, 1 иргэн нь хөлөө хугалчихсан байгаа.

Зөөврийн хайрцгаар санал өгөх иргэд нь өндөр настай, хорт хавдартай хүмүүс байгаа.

Сул хараатай иргэдэд зориулан томруулдаг шил 1 ширхэгийг сонгуулийн тойргийн хорооноос өгсөн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгайлан тоноглогсон санал авах бүхээг байхгүй байв.

**40 дүгээр хэсгийн хороо** нь 2 давхарт байрлаж байв.Налуу замтай.

Хөгжлийн бэрхшээлтэй 3 иргэн байгаа.

Зөөврийн хайрцгаар санал өгөх 14 иргэн байгаа.

Сул хараатай иргэдэд зориулан томруулдаг шил 1 ширхэгийг сонгуулийн тойргийн хорооноос өгсөн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгайлан тоноглогсон санал авах бүхээг байхгүй байв.

**41 дүгээр хэсгийн хороо** нь 1 давхарт байрлаж байв. Налуу замгүй

Хэсгийн хорооныхоо халамжийн мэргэжилтэнтэйгээ хамтарч судалсны үндсэн дээр 9 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаа. Явж чадахүй болон тэргэнцэртэй иргэн байхгүй хэмээн хэсгийн хорооны дарга Гаваа тайлбарлаж байв.

Сул хараатай иргэдэд зориулан томруулдаг шил 1 ширхэгийг сонгуулийн тойргийн хорооноос өгсөн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгайлан тоногловсон санал авах бүхээг байхгүй байв.

**42 дугаар хэсгийн хороо** нь 2 давхарт байрлаж байв. Налуу замгүй.

Хөгжлийн бэрхшээлтэй 2 иргэн байгаа. 1 иргэн нь зөөврийн хайрцагар, 1 иргэн нь өөрийн биеэр ирж саналаа өгөх хүсэлтээ гаргасан.

Тусгайлсан бүхээг хийж, таних тэмдэгтэй нь байрлуулахаар төлөвлөж байна.

Сул хараатай иргэдэд зориулан томруулдаг шил 1 ширхэгийг сонгуулийн тойргийн хорооноос өгсөн байна.

**43 дугаар хэсгийн хороо** нь 1 давхарт байрлаж байв. Налуу замгүй.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн байхгүй.

Хэвтэрийн болон харвасан, өндөр настай, хорт хавдартай 33 иргэн байгаа бөгөөд зөөврийн хайрцагар саналаа өгнө.

Зөөврийн хайрцагныхаа тодорхой бүдүүвч зургийг гарган ажиллаж байгаа.


Хорооны судалгаагаар тэргэнцэртэй болон харааны бэрхшээлтэй иргэн байхгүй учир налуу зам болон тусгайлсан бүхээг байршуулах шаардлагагүй гэж үзэж байгаа.

Сул хараатай иргэдэд зориулан томруулдаг шил 1 ширхэгийг сонгуулийн тойргийн хорооноос өгсөн байна.

**44 дүгээр хэсгийн хороо** нь 2 давхарт байрлаж байв. Залуу замгүй.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан тусгайлан тоногловсон санал бэлтгэх бүхээг байгаа.

Сул хараатай иргэдэд зориулан томруулдаг шил 1 ширхэгийг сонгуулийн тойргийн хорооноос өгсөн байна.



## Дүгнэлт

-Чингэлтэй дүүргийн 24 тойргийн хэсгийн хороодоос Чингэлтэй дүүргийн 18 болон хэсгийн 31 хороодын барилга нь стандартын дагуу баригдсан байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд саадгүй орж гарах боломжтой байв.

-Бусад хэсгийн хороодын байруудад хөгжлийн бэрхшээлтэй иргэд сонгуулийн саналаа өгөхдөө чөлөөтэй орох, гарах налуу зам, зөөврийн шат огт байхгүй байв. Зөөврийн налуу замыг бэлтгээгүй байв. Үүнээс үзэхэд сонгуулийн санал авах байрууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжгүй байна.

-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан санал бэлтгэх тусгайлан тоногдсон бүхээгийг бэлтгэсэн хороод цөөхөн байна.

-Харин бүх хэсгийн хороод сул хараатай иргэдэд зориулсан томруулдаг шилийг ашиглахаар байна.



## ИЛТГЭХ ХУУДАС

2012 оны 06 дугаар сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

ХЭҮК-оос иргэдийн сонгох эрхийн хэрэгжилтэд хийж буй мониторингийн удирдамжийн дагуу Монгол Улсын Их Хурлын болон Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийг зохион байгуулж явуулахдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэгш эрхийн оролцоог хангах, Үндсэн Хууль, олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцоор баталгаажсан сонгох эрхийг хангах үүднээс Чингэлтэй дүүргийн сонгуулийн 24 дүгээр тойргийн сонгуулийн 1-15 дугаар хэсгийн хороодод дараах байдлаар ажиглалт хийлээ.

1. УИХ-ын сонгуулийн хэсгийн хорооны болон санал авах байрыг бэлтгэхдээ зааврын 3 дугаар зүйлийн 3.3.3-т заасан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж тоногосон, нэгээс доошгүй тооны санал бэлтгэх бүхээ”-г хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй хэлбэрээр тоноглох засах, санал авах байруудын орц, гарцанд налуу зам байрлуулсан эсэх
2. Санал бэлтгэх бүхээгт сул хараатай сонгогчдод зориулан томруулдаг шил байрлуулсан эсэх
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ байршуулсан эсэх.

**1 дүгээр хэсгийн хороо** Санал авах байр Чингэлтэй дүүргийн 23 дугаар сургуулийн 4 давхарт биеийн тамирын зааланд байрлаж байв. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд орох, гарахад зориулагдсан налуу зам байхгүй. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс зөврийн саналын хайрцагаар санал авах тул зөврийн налуу замыг бэлтгээгүй талаар хэсгийн хорооны гишүүд тайлбарлав.

Сул хараатай иргэдэд зориулан томруулдаг шил 1 ширхэгийг сонгуулийн тойргийн хорооноос өгсөн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан тусгайлан тоногосон санал бэлтгэх бүхээг байхгүй байв.

**2 дугаар хэсгийн хороо** нь 2 дугаар хорооны хурлын танхимд /подвольд/ байрлаж байв. Налуу замгүй.

Сул хараатай иргэдэд зориулан томруулдаг шил 1 ширхэгийг сонгуулийн тойргийн хорооноос өгсөн байна.

**3-4 дүгээр хэсгийн хороод** нь 24 дүгээр сургуулийн нэгдүгээр давхарт урлагийн танхим болон спортын зааланд байрлаж байв. Налуу замгүй.

Сул хараатай иргэдэд зориулан томруулдаг шил 1 ширхэгийг сонгуулийн тойргийн хорооноос өгсөн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан тусгайлан тоногосон санал бэлтгэх бүхээг байхгүй байв.

**5 дугаар хэсгийн хороо** Нийслэлийн Онцгой Байдлын газрын хурлын танхимд байрлаж байв. Налуу замгүй.

Сул хараатай иргэдэд зориулан томруулдаг шил 1 ширхэгийг сонгуулийн тойргийн хорооноос өгсөн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан тусгайлан тоногосон санал бэлтгэх бүхээг байхгүй байв.

УИХ.МН  
СУДАЛГААНЫ САН

**6 дугаар хэсгийн хороо** 5 дугаар сургуулийн биеийн тамирын зааланд байрлаж байв. Тус барилга нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу замгүй. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс зөөврийн саналын хайрцагаар санал авах тул зөөврийн налуу замыг бэлтгээгүй талаар хэсгийн хорооны гишүүд тайлбарлав.

Сул хараатай иргэдэд зориулан томруулдаг шил 1 ширхэгийг сонгуулийн тойргийн хорооноос өгсөн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан тусгайлан тоноглосон санал бэлтгэх бүхээг байхгүй байв.

**7 дугаар хэсгийн хороо** нь ЧД-ийн “Чимэг” төвийн 2 давхарт байрлаж байв. Налуу замгүй. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс зөөврийн саналын хайрцагаар санал авах тул зөөврийн налуу замыг бэлтгээгүй талаар хэсгийн хорооны гишүүд тайлбарлав.

Сул хараатай иргэдэд зориулан томруулдаг шил 1 ширхэгийг сонгуулийн тойргийн хорооноос өгсөн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан тусгайлан тоноглосон санал бэлтгэх бүхээг байхгүй байв.

**8 дугаар хэсгийн хороо** нь Хөдөлмөрийн дээд сургуулийн 2 давхарт байрлаж байв. Налуу замгүй. Хөгжлийн бэрхшээлтэй тэргэнцэртэй 7 иргэн байгаа. Тэднээс зөөврийн саналын хайрцагаар санал авах тул зөөврийн налуу замыг бэлтгээгүй талаар хэсгийн хорооны гишүүд тайлбарлав.

Сул хараатай иргэдэд зориулан томруулдаг шил 1 ширхэгийг сонгуулийн тойргийн хорооноос өгсөн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан тусгайлан тоноглосон санал бэлтгэх бүхээг байхгүй байв.

**9 дүгээр хэсгийн хороо** нь ЧД-ийн 6 дугаар хорооны хурлын зааланд байрлаж байв. Уг хорооны барилга шинээр баригдсан, налуу замтай байв.

Биднийг очиход тухайн хэсгийн хороо ажиллаагүй хаалга нь цоожтой байсан тул дотогш орж танилцаж чадаагүй.

**10 дугаар хэсгийн хороо** нь 50 дугаар сургуулийн урлагийн зааланд байрлаж байв. Санал өгөх байр руу ороход налуу замгүй, гарах хаалга нь налуу замтай байсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс зөөврийн саналын хайрцагаар санал авах тул зөөврийн налуу замыг бэлтгээгүй талаар хэсгийн хорооны дарга Даваахүү тайлбарлав.

Сул хараатай иргэдэд зориулан томруулдаг шил 2 ширхэгийг сонгуулийн тойргийн хорооноос өгсөн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан тусгайлан тоноглосон санал бэлтгэх бүхээг байхгүй боловч өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд орж ирэхэд зориулж өндөр, нам сандлыг тавьсан байв.

**11 дүгээр хэсгийн хороо** нь 7 дугаар хорооны хурлын танхимд нэг давхарт байрлаж байв. Налуу замгүй. Биечлэн ирж санал өгөх боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс зөөврийн хайрцагаар санал авах учраас зөөврийн налуу зам бэлтгээгүй талаар хэсгийн хорооны гишүүн Пүрэвсүрэн тайлбарлав.

Сул хараатай иргэдэд зориулан томруулдаг шил 1 ширхэгийг сонгуулийн тойргийн хорооноос өгсөн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан тусгайлан тоногловсон санал бэлтгэх бүхээг байхгүй байв.

**12 дугаар хэсгийн хороо** нь 173 дугаар цэцэрлэгийн байранд нэг давхарт байрлаж байв. Уг барилга нь шинээр баригдсан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан налуу замгүй хэдий ч огт шат байхгүй, хаалга нь босгогүй байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд саадгүй орох боломжтой байв.

Сул хараатай иргэдэд зориулан томруулдаг шил 1 ширхэгийг сонгуулийн тойргийн хорооноос өгсөн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан тусгайлан тоногловсон санал бэлтгэх бүхээг байхгүй байв.

**13 дугаар хэсгийн хороо** нь Зурагтын шинэ эцэст байрлах дэлгүүрийн байранд байрлаж байв. Налуу замгүй, зөөврийн зам байхгүй байв. Зөөврийн налуу зам бэлтгэх талаар яригдаж байгаа гэж хэсгийн хорооны гишүүд тайлбарлаж байв. хөгжлийн бэрхшээлтэй 18 иргэн зөөврийн саналын хайрцагаар санал өгна гэв.

Сул хараатай иргэдэд зориулан томруулдаг шил 1 ширхэгийг сонгуулийн тойргийн хорооноос өгсөн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан тусгайлан тоногловсон санал бэлтгэх бүхээг байхгүй байв.

**14 дүгээр хороо** нь Маргад-Оч хүнсний дэлгүүрт байрлаж байв. Зөөврийн налуу замгүй, бэлтгээгүй байв.

Сул хараатай иргэдэд зориулан томруулдаг шил 1 ширхэгийг сонгуулийн тойргийн хорооноос өгсөн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан тусгайлан тоногловсон санал бэлтгэх бүхээг байхгүй байв.

**15 дугаар хэсгийн хороо** нь 8 дугаар хорооны хурлын танхимд /подвольд/ байрлаж байв. Налуу зам огт байхгүй. Зөөврийн налуу зам бэлтгээгүй байв. Хөгжлийн бэрхшээлтэй зарим иргэд зөөврийн саналын хайрцагаар санал өгөхгүй өөрсдөө биечлэн ирж өгнө гэж байгаа. Энэ тохиолдолд хэсгийн хорооны ажилчид хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тусалж санал авах оруулж, гаргах талаар хэсгийн хорооны гишүүн Золзаяа тайлбарлав.

Сул хараатай иргэдэд зориулан томруулдаг шил 1 ширхэгийг сонгуулийн тойргийн хорооноос өгсөн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан тусгайлан тоногловсон санал бэлтгэх бүхээг байхгүй байв.

Чингэлтэй дүүргийн 24 тойргийн 1-15 дугаар хэсгийн хороодоос зөвхөн Чингэлтэй дүүргийн 6 дугаар хорооны барилга нь стандартын дагуу налуу замтай баригдсаныг эс тооцвол нийт хэсгийн хороодын санал авах байруудад хөгжлийн бэрхшээлтэй иргэд сонгуулийн саналаа өгөхдөө чөлөөтэй орох, гарах налуу зам, зөөврийн шат огт байхгүй байв.

## Дүгнэлт:

- Чингэлтэй дүүргийн 24 тойргийн хэсгийн хороодоос Чингэлтэй дүүргийн 6 дугаар хорооны барилга нь стандартын дагуу налуу замтай баригдсан, 12 дугаар хэсгийн хороо нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан налуу замгүй хэдий ч огт шат байхгүй, хаалга нь босгогүй байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд саадгүй орох боломжтой байв.
- Бусад хэсгийн хороодын санал авах байруудад хөгжлийн бэрхшээлтэй иргэд сонгуулийн саналаа өгөхдөө чөлөөтэй орох, гарах налуу зам, зөөврийн шат огт байхгүй байв. Зөөврийн налуу замыг бэлтгээгүй байв. Үүнээс үзэхэд сонгуулийн санал авах байрууд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжгүй байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан санал бэлтгэх тусгайлан тоногдсон бүхээгийг бэлтгэсэн хэсгийн хороо байхгүй байна.
- Харин бүх хэсгийн хороодод сул хараатай хүмүүст зориулсан томруулдаг шилийг ашиглахаар байна.



ОРОН НУТГИЙН ЦАГДААГИЙН ГАЗАР, ХЭЛТЭСТ ТҮР БОЛОН АЛБАДАН  
СААТУУЛАГДСАН ШҮҮХИЙН ШИЙДВЭРЭЭР  
БАРИВЧИЛАГДСАН ХҮНИЙ СУДАЛГАА


2012.06.25

Улаанбаатар хот

ШҮҮХИЙН ШИЙДВЭРЭЭР БАРИВЧИЛАГДСАН ИРГЭД

№	Аймгийн нэрс	06.25 өнөөдрийн байдлаар	06.26 Гарах хүн	06.27 Гарах хүн	06.28 Гарах хүн	Санал өгөх нийт хүн
1	Архангай	1				1
2	Баянхонгор	5			1	4
3	Баян-Өлгий	5		1		4
4	Булган	2		1		1
5	Дархан-Уул	6	2	2		2
6	Дорнод	4				4
7	Дорноговь	10	4	1		5
8	Дундговь	1				1
9	Завхан	6		4		2
10	Говьсүмбэр	1				1
11	Говь-Алтай	3		1		2
12	Төв	6	3	3		0
13	Өвөрхангай	5	1	2		2
14	Өмнөговь	3				3
15	Сэлэнгэ	12	2	1	2	7
16	Сүхбаатар	3		1		2
17	Орхон	27	2	2		23
18	Увс	0	0	0	0	0
19	Ховд	8	1	2		5
20	Хөвсгөл	9	2	3		4
21	Хэнтий	2				2
	НИЙТ	119	17	24	3	75

Орон нутгийн цагдаагийн газар хэлтэст түр болон албадан саатуулагдсан иргэн одоогийн байдлаар байхгүй байна.



НИЙГМИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХ ГАЗАР